



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2018 оны 01 сарын 11 өдөр

АКТ  
Дугаар 09

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Эрдэнэцогт сумын Соёлын төвийн 2017 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланд заварын аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгууллагын дансанд өөрийн орлогын 19,0 мянган төгрөгийг Э.Сугараас тушаасан баримттай боловч уг орлого байгууллагын дансанд ороогүй, нэр данс зөрүүтэйн улмаас ажилтны дансанд буцан орсон байхад орлогыг залруулж байгууллагын дансанд төвлөрүүлээгүй.

2. Байгууллагын дарга 2017.01.03-ны өдрийн 02 тоот тушаалаар бүжгийн багш Д.Дамдинжавт 01 дүгээр сарын цалинг 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан байхад нягтлан бодогч тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй.

3. Ажиллагсдын цалин, ээлжийн амралтын нөхөн олговрыг давтан тооцоолж шалгахад төсвийн захирагч Л.Ганчимэгт 33,3 мянга, ажилтан Б.Мөнхсайханд 48,1 мянга, Б.Цэрмаад 15,4 мянга, нийт 96,8 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно” гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд

2517045

баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон", 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дутуу олгосон цалингийн 96800 төгрөгийг ажилтнуудад буцаан олгохоор төлбөрийн акт тогтоов.

2. Өөрийн орлогын 19,0 мянган төгрөгийг Э.Сугараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.


3. Байгууллагын даргын 2017 оны 02 тоот тушаалыг хэрэгжүүлж, багш Д.Дамдинжавын цалингаас 89,3 мянган төгрөг суутгах төлбөрийн акт тогтоов.

4. Аудитаар тогтоосон 205,171 төгрөгийг Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

5. Аудитаар тогтоосон 205,171 төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.02.10-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэцогт сумын Соёлын төвийн төсвийн менежер Л.Ганчимэг, нягтлан бодогч Ү.Банзрагч нарт хариуцуулав.

#### АКТ

**ТОГТООСОН:**  
АХЛАХ АУДИТОР  
  
Б.ДОЛЖМАА  
6417143544  
БНУА0067 9007423

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
Л.ГАНЧИМЭГ  
НЯГТЛАН БОДОГЧ  
  
Ү.БАНЗРАГЧ

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2018 оны 01 сарын 13 өдөр

АКТ  
Дугаар 10

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Баян-Овоо сумын Цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Явуулын бүлгийн багш О.Буяндэлгэрт 2017 оны 2 дугаар сард Засгийн газрын 90-р тогтоолын нэмэгдэлд 18.9 мянган төгрөгийг илүү олгосон.
2. Явуулын багш Г.Должинсүрэнд 4.5 дүгээр сард Засгийн газрын 90-р тогтоолын нэмэгдэлд 107,0 мянган төгрөгийг байгууллагын даргын шийдвэргүйгээр олгосон.
3. Тайлант онд 10464 хүүхэд өдөр цэцэрлэгт хамрагдсан бөгөөд хүүхдийн хоолны зардалд нормативт зардлаас 124.1 мянган төгрөгийг илүү зарцуулсан.
4. 2017 оны 07 дугаар сард нүүдлийн бүлгийн туслах багшаар ажиллаж байсан О.Буяндэлгэрт 648469 төгрөгийн цалин олгосон байхад Нийгмийн даатгалын хэлтэст цалинг 982384 төгрөгөөр буюу 333915 төгрөгөөр илүү мэдээлснээс илүү мэдээлэгдсэн цалингийн нийгмийн даатгалын шимтгэлд 70,1 мянган төгрөгийг илүү төлсөн.
5. Байгууллагын даргын 2017.04.17 өдрийн Б/13 тоот тушаалаар үйлчлэгч И.Төрсайханд сахилгын шийтгэл ногдуулсан байхад үр дүнгийн урамшуулал олгосон.
6. Өвсний үнэнд урьдчилж 220.0 мянган төгрөгийг 2017.11.02-ны өдөр шилжүүлж, ажилтнуудаас 200.0 мянган төгрөг суутгаж, ажилтан Д.Лхагважаваас 20.0 мянган төгрөгийг суутгаагүй байна.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", УИХ-ын 2017 оны 67 тоот тогтоолын 1 дэх, Засгийн газрын 2012 оны 106 тоот тогтоолын 2 дахь "Цэцэрлэгийн хүүхэд бүрийн

2517047

нэг өдрийн хоолны зардлыг ... цэцэрлэгт 1650 төгрөгөөр ... тогтоосугай” зэрэг заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь ““Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон”, 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон цалингийн 18,993 төгрөгийг явуулын бүлгийн багшаар ажиллаж байсан О.Буяндэлгэрээр, 107,060 төгрөгийг багш Г.Должинсүрэнгээр, сахилгын шийтгэлтэй байхад олгосон үр дүнгийн урамшууллын 270,000 төгрөгийг ажилтан И.Төрсайханаар, цалингаас суутгаагүй өвсний 20,000 төгрөгийг Д.Лхагважаваар тус тус төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.


2. Хүүхдийн хоолны зардалд илүү олгосон 124189 төгрөгийг байгууллагын дарга, нягтлан бодогч, нярав нараар хувь тэнцүүлэн төлүүлэхээр, нүүдлийн бүлгийн багшаар ажиллаж байсан О.Буяндэлгэрийн илүү мэдээлэгдсэн цалинд ногдох НДШ-ийн 70,122 төгрөгийг нягтлан бодогч Л.Алимаагаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Аудитаар тогтоосон 610,364 төгрөгийг Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

4. Төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.05.30-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Овоо сумын Цэцэрлэгийн төсвийн захирагч Э.Цэндбазар, нягтлан бодогч Л.Алимаа нарт хариуцуулав.

#### АКТ

**ТОГТООСОН<sup>1</sup>:**  
АХЛАХ АУДИТОР  
  
Б.ДОЛЖМАА  
6417143544  
БНДА00067 5007423

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
  
Э.ЦЭНДБАЗАР  
НЯГТЛАН БОДОГЧ  
  
Л.АЛИМАА

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 16

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Эрдэм ахлах сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2017 оны 12 дугаар сард "Тосуйн гол" ХХК-д үдийн цайнд хамрагдсан хүүхэд өдрийн гүйцэтгэлээс 209.2 мянга, "Их тэнгэрийн хүч" ХХК-д 47.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байхад илүү шилжүүлсэн зардлыг авлагаар бүртгэлгүй, тухайн тайлант хугацааны зардлаар бүртгэсэн байна.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон", 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үдийн цайны зардалд илүү олгосон 47.0 мянган төгрөгийг "Их тэнгэрийн хүч" ХХК-аар, 209,2 мянган төгрөгийг "Тосуйн гол" ХХК-аар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Аудитаар тогтоосон 255,600 төгрөгийг Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2517059

3. Төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.02.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор сумын Эрдэм ахлах сургуулийн төсвийн захирагч Ц.Загдсүм, нягтлан бодогч Ч.Мэнд-Амар нарт хариуцуулав.

**АКТ**

**ТОГТООСОН:**  
АХЛАХ АУДИТОР  
  
Б.ДОЛЖМАА  
6417143544  
БЧОА0067 9007423

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
Ц.ЗАГДСҮМ  
НЯГТЛАН БОДОГЧ  
Ч.МЭНД-АМАР

1.Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.